

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН” ТӨААТҮГ

**КОМПЬЮТЕР, ПРИНТЕР ТЕХНИК ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын нэр: **КОМПЬЮТЕР, ПРИНТЕР ТЕХНИК ХЭРЭГСЭЛ
ХУДАЛДАН АВАХ**

Тендер шалгаруулалтын дугаар: **ЭХЭЗХ/202001001**

Ажлын хэсгийн ахлагч:	Х.Самбалхүндэв
Гишүүн	Э.Золзаяа Б.Наранбаатар С.Насанжаргал О.Бат-Амгалан Ц.Санчин
АХНБД	Д.Гүррагчаа

2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Компьютер, принтер техник хэрэгсэл”-ийг** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 07 дугаар сарын 27-ны 14 цаг 00 минут**-аас өмнө **цахим** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 14 цаг 30 минут**-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх.¹

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Хаяг: **Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо, Х.Чингүнжавын гудамж, ЭХЭЗХ-ийн байр**

Утас: **86921202**

¹ Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ	
Гурав. ТӨӨЗ - ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 2019 оны жилийн санхүүгийн тайлан</p> <p>Сүүлийн 2018, 2019 оны аль нэг жилд гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл/гэрээний хуулбар/</p> <p>Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо, Х.Чингүнжавын гудамж, ЭХЭЗХ-ийн байр</p> <p>2020 оны 07 дугаар сарын 27-ны 14 цаг 00 минут-аас өмнө хүлээн авна.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо, Х.Чингүнжавын гудамж, ЭХЭЗХ-ийн байр</p> <p>2020 оны 07 дугаар сарын 27-ны 14 цаг 30 минут-т тендерийг нээнэ.</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

№	Тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг
1	Суурин компьютер /иж бүрэн/	<ul style="list-style-type: none"> • Эх хавтан: ASUS ROG Strix Z-390-F • Процессор / CPU: 9th Generation Intel Core i9-9900k 5.1Ghz Шуурхай санах ой / RAM: 32GB(2x16) DDR4 HyperX RGB 3600MHz C16 Хатуу диск : 1TB M.2 NVMe/SSD/ + 2T /HDD/ График карт: GeForce RTX2080 8GD6 Оптик драйв: 802.11 ac (2*2) + BT 5.0,DVD+/-RW Тэжээлийн блок: Бүх төхөөрөмжийг хангаж чадахуйц Оролт гаралтууд: • Дэлгэц: 27” IPS, Full HD ч Нягтрал: 1920 x 1080 60hz түүнээс дээш • Дагалдах хэрэгсэл: Keyboard /Rubber dome/ Mouse Speakers Kaspersky анти-вирусны хамгаалалт Өнгө: Хар • Баталгаат хугацаа: 1 жил 	1
2	Суурин компьютер /иж бүрэн/	<ul style="list-style-type: none"> • Эх хавтан: ASUS ROG Strix Z-390-F • Процессор / CPU: 9th Generation Intel Core i7-9700 Шуурхай санах ой / RAM: 16GB DDR4 3200MHz C16 Хатуу диск : 512GB M.2/SSD/ + 1T /HDD/ График карт: GeForce GTX1660 6GD5 Оптик драйв: 802.11 ac (2*2) + BT 5.0,DVD+/-RW Тэжээлийн блок: Бүх төхөөрөмжийг хангаж чадахуйц Оролт гаралтууд: • Дэлгэц: 27” IPS, Full HD ч Нягтрал: 1920 x 1080 60hz түүнээс дээш • Дагалдах хэрэгсэл: Keyboard /Rubber dome/ Mouse Speakers Kaspersky анти-вирусны хамгаалалт Өнгө: Хар • Баталгаат хугацаа: 1 жил 	1

3	Суурин компьютер /иж бүрэн/	<p>Процессор / CPU: 9th Generation Intel Core i7-9700 Шуурхай санах ой / RAM: 8GB DDR4 2666 MHz</p> <p>Хатуу диск : 256GB M.2/SSD/ + 1T /HDD/</p> <p>График карт: GTX 1050 with 3 GB</p> <p>Оптик драйв: Tray load DVD Drive (Reads and Writes to DVD/CD)</p> <p>Оролт гаралтууд: (2) USB 3.0, (1) Universal Audio Jack (4) USB 2.0 RJ-45 HDMI VGA 3-stack audio jacks supporting 5.1 surround sound (2) PCIe x 1, PCIe x 16, PCI (3653 only)</p> <ul style="list-style-type: none"> • Дэлгэц: 24 inches болон түүнээс дээш • Нягтрал: 1920 x 1080 at 60 Hz түүнээс дээш • Дагалдах хэрэгсэл: Keyboard /Rubber dome/ Mouse Speakers Kaspersky анти-вирусны хамгаалалт • Өнгө: Хар • Баталгаат хугацаа: 1 жил 	8
4	Зөөврийн компьютер	<ul style="list-style-type: none"> • Процессор / CPU: i7 9th gen • Шуурхай санах ой / RAM: 8-16GB • Хатуу диск : 512GB M.2 SSD • Дэлгэц: 15.6 inch • Нягтрал: 1920*1080 • Kaspersky анти-вирусны хамгаалалт • Баталгаат хугацаа: 1 жил 	1
5	Олон үйлдэлт өнгөт хувилагч	<ul style="list-style-type: none"> • Функц: Хэвлэх, хувилах, сканнер A4/A3 /Өнгөт/ Хэвлэх хурд: 1 минутанд 20/10 хуудас түүнээс дээш Хэвлэх нягтрал: 1200/1200 dpi Хувилах хурд: 1 минутанд 20/10 хуудас түүнээс Хувилах нягтрал: 1200/1200 dpi Сканнер нягтрал: 600 dpi Duplex print: 2 талаараа хэвлэх Дэлгэц: Процессорын хурд: Холболт: Hi-Speed USB 2.0 Цаасны оролт: A3, A4, A5, A6 B5, 52 – 300 g/m² Automatic paper sensor: тийм Автомат цаас татагч: Тийм Windows: Windows 10 (32-bit/64-bit), Windows 8 (32/64-bit), Windows 7 (32/64-bit) 	1

		Баталгаат хугацаа: 1 жил Хор дагалдах: Тийм /бүх өнгө/	
6	Олон үйлдэлт өнгөт принтер	<ul style="list-style-type: none"> Хэвлэлт: Лазер Функц: Хэвлэх, хувилах, сканнер /Өнгөт/ Хэвлэх хурд: 16/16 ppm түүнээс дээш Хэвлэх нягтрал: 600/600 dpi буюу түүнээс дээш Хувилах хурд: 16/16 ppm буюу түүнээс дээш Хувилах нягтрал: 600/600 dpi буюу түүнээс дээш Сканнер нягтрал: 300 dpi буюу түүнээс дээш Сканнер хурд: 14 ppm буюу түүнээс дээш Дэлгэц: 2-Line LCD – эсвэл түүнтэй ойролцоо Холболт: Hi-Speed USB 2.0 Цаасны оролт: A4, B5, 90 g/m² Windows: Windows 10 (32-bit/64-bit), Windows 8 (32/64-bit), Windows 7 (32/64-bit) Баталгаат хугацаа: 1 жил Хор дагалдах: Тийм /бүх өнгө/ 	1
7	Олон үйлдэлт өнгөт принтер	<ul style="list-style-type: none"> Функц: Хэвлэх, хувилах, сканнер /Өнгөт/ Хэвлэх хурд: 33/15 ppm түүнээс дээш Хэвлэх нягтрал: 5760x1440 dpi - ойролцоо Хувилах хурд: 20 хүртэл түүнээс дээш Хувилах нягтрал: Сканнер нягтрал: 600x1200 dpi Дэлгэц: 2-Line LCD – эсвэл түүнтэй ойролцоо Холболт: Hi-Speed USB 2.0 Цаасны оролт: A4, A5, A6, B5 70 g/m² Windows: Windows 10 (32-bit/64-bit), Windows 8 (32/64-bit), Windows 7 (32/64-bit) Баталгаат хугацаа: 1 жил Хор дагалдах: Тийм/бүх өнгө/ 	2

2. **Стандарт:** Монгол улсын стандарт, дүрэм журамд нийцсэн байна.

3. **Баглаа, боодол:** Зориулалтын баглаа боодолтой байна.

4. **Бараа хүргэх газар:** Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо, Х.Чингүнжавын гудамж, ЭХЭЗХ-ийн байр

5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

1	Суурин компьютер	1	ш	Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ-ын байр	Ажлын 15 хоногт	Ажлын 20 хоногт	
2	Суурин компьютер	1	ш				
3	Суурин компьютер	8	ш				
4	Зөөврийн компьютер	1	ш				
5	Олон үйлдэлт өнгөт хувилагч	1	ш				
6	Олон үйлдэлт өнгөт принтер	1	ш				
7	Олон үйлдэлт өнгөт принтер	2	ш				

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|---|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Компьютер, принтер, дагалдах хэрэгслийг угсарч, анти-вирусны программыг ажиллуулж хэвийн ажиллагааг шалгаж туршина. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
Чанарын баталгаат хугацаа 1 жил байна. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | Барааг заасан хаягт хүргэж, туршилт шалгалт хийж хүлээн авсан акт үйлдсэний дараа ажлын 5 хоногт багтаан тендерийн үнийн дүнг 100% нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9) ² | 9.1. Алданги оногдуулах хувь: 0,05%
Алдангийн нийт дүн: 10% |

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг⁴;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

³ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

⁴ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]